



МОНГОЛ УЛС
БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2020 оны 02 сарын 10 өдөр

Дугаар А/84

Номгон

Г “Мандал хайрхан” хүнсний дэлгүүрийн
“Согтууруулах ундаа худалдах тусгай
зөвшөөрөл”-ийг хүчингүй болгох тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.6-ын “а” дахь заалт, Тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1.4, Аймгийн ИТХ-ын хуралдааны 2018 оны 14/08 дугаар тогтоолоор батлагдсан “Согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрөл олгох, сунгах, түдгэлзүүлэх, хүчингүй болгох журам”-ын 6.1.8, 10.2, Аймгийн Засаг даргын 2018 оны “Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хуулийн хэрэгжилтийг хангах тухай” 03 дугаар албан даалгаврын 2 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:


1. Аймгийн Цагдаагийн газрын даргын 2020 оны 28-1/187 дугаар албан бичгээр ирүүлсэн мэдэгдлийн дагуу Ж.Баярсайхан эзэнтэй “Мандал хайрхан” хүнсний дэлгүүрийн “Согтууруулах ундаа худалдах тусгай зөвшөөрөл”-ийг 2 жилийн хугацаагаар хүчингүй болгосугай.

2. Ж.Баярсайхан эзэнтэй “Мандал хайрхан” хүнсний дэлгүүрийн үйл ажиллагаанд байнгын хяналт тавьж ажиллахыг Цагдаагийн газрын дарга /Ц.Анхбаяр/-д үүрэг болгосугай.

3. Холбогдох хууль болон “Согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрөл олгох, сунгах, түдгэлзүүлэх, хүчингүй болгох журам”-ыг мөрдөж ажиллахыг согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрөл бүхий нийт аж ажуйн нэгж, иргэдэд даалгасугай.

4. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хууль, эрх зүйн хэлтэс /Д.Сарангарав/-т даалгасугай.

ДАРГА



Г.БАТЖАРГАЛ

1200077